

НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР



НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

/Нэгдүгээр улирлын байдлаар /

УЛААНБААТАР ХОТ
2018 ОНЫ 4 ДҮГЭЭР САР

НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ

2018.04.03.

№	Агуулга	Зорилтын тоо	Хэрэгжилтийн явц		Хувь %
			70	40	
1	ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ ӨРХ БҮРТ	4	2	2	55,0
2	БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ	2	1	1	55,0
3	ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НИЙГМИЙН БОДЛОГО	2	-	2	40,0
4	ЗАСАГЛАЛ	1	-	1	40,0
НИЙТ		9	3	6	50,0

**НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2018 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛЭЭС ЧИНГЭЛТЭЙ
ДҮҮРЭГТ ХАМААРАХ ЗААЛТЫН БИЕЛЭЛТ**

№	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн заалт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах байгууллага	Шалгуур үзүүлэлт	2018 онд хүрэх түвшин, үр дүн	Шаардлагатай хөрөнгийн хэмжээ /сая.төг/, хөрөнгийн эх үүсвэр
		Өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, ажлын байр олноор бий болгосон үйлдвэрлэл эрхлэгчдийг шалгаруулан, урамшуулж сурталчилна.	ЖДҮДТ НӨҮГ, Дүүргүүд	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувь	50	20,0 Нийслэлийн төсөв
1	1.2.3 Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж байнгын ажлын байр шинээр бий болгосон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	Кластерын төвд дүүргийн 7, 9, 10, 12, 14, 17 дугаар хорооны нийт 12 иргэн тогтмол хамрагдаж байна. 1 дүгээр улирлын байдлаар нийт 15 үйлдвэрлэгч 35.0 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бөгөөд цагаан сарын баяртай холбогдуулан үндэсний дээл, хүрэм хантаас цамц оёх захиалга өссөн ба 2-3 оёдолчид нэг баг бүрдүүлж, хувцас эсгэх, оёх, дээл хавах, шилбэ хадах зэрэг оёдлын үйл ажиллагааг дамжлагын системээр хийж гүйцэтгэсэн нь цаг хугацаа болон эдийн засгийн хэмнэлттэй үзүүлэлт гарсан. Тайлангийн хугацаанд Кластерын төвд хамрагдаж буй үйлдвэрлэгч нар нийт 45 сая төгрөгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн байна. Сар шинийн баярыг угтан дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Нэг Архангай” төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулсан “Цагаан сарын үзэсгэлэн худалдаа 2018” үзэсгэлэн худалдааны үеэр дүүргийн Кластерын төвийн оёдолчдоор үзэсгэлэнд оролцсон иргэдэд 250 хормогч, ханцуйвч нийт 1.6 сая			40	-

		төгрөгийн хувцсаар жигдрүүлэх ажлыг хийсэн. Бизнес эрхлэгчдэд аж ахуй эрхлэх ур чадварыг олгох хөтөлбөрийн сургалт, бизнес эрхлэгч хувь хүний болон бизнесийн хөгжлийг дээшлүүлэх зорилгоор нийт 3 удаагийн сургалтад өссөн дүнгээр 40 үйлдвэрлэгч хамруулаад байна.				
		"Улаанбаатарт үйлдвэрлэв" хөтөлбөрийн хүрээнд жижиг, дунд үйлдвэрийн бараа бүтээгдэхүүний борлуулалтыг нэмэгдүүлэх боломжоор хангах ажлыг зохион байгуулна.	ЖДҮДТ НӨҮГ, Дүүргүүд	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувь	50	20,0 Нийслэлийн төсөв
2	1.2.4 "Улаанбаатарт үйлдвэрлэв" хөтөлбөр хэрэгжүүлж, үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний өрсөлдөх чадварыг дүүргүүдэд жигд хөгжүүлнэ.	"Чингэлтэйд үйлдвэрлэв" борлуулалтын цэгүүдийн тогтвортой үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор дүүргээс эдийн засгийн болон мэргэжил арга зүйн удирдлагаар тогтмол ханган ажиллуулснаар үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний тоо, өнгө үзэмж, чанар, сав баглаа боодол сайжирч худалдан авагчдад танигдсан бараа бүтээгдэхүүний тоо өсөж, борлуулалтын орлого байнга өссөн үзүүлэлттэй байна. Чингэлтэйд үйлдвэрлэв" 1, 2 дугаар салбар дэлгүүрүүдэд нийт 167 үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж, 2018 оны нэгдүгээр улирлын байдлаар нийт 92.4 сая төгрөгийн борлуулалт хийсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 31.5 сая төгрөгөөр буюу 34 хувиар өссөн үзүүлэлттэй байна. "Чингэлтэйд үйлдвэрлэв"-3 салбар дэлгүүрийг дүүргийн 12 дугаар хороо, Нарантуул-2 худалдааны төвийн хажууд нээж ажиллуулж эхэлсэн бөгөөд тус байрны халаалт, цэвэр усны шугам хоолой, барилгын дотор гадна заслыг олон улсын байгууллагын 25,0 сая төгрөгөөр засварлаж, дүүргийн төсвийн 2,0 сая төгрөгөөр гадна хаягийг шинээр хийлгэсэн. Тус салбар дээр Цагаан сарын өргөтгөсөн худалдааг 1 сарын хугацаанд зохион байгуулж, 12 иргэний 18-20 нэр төрлийн			70	-

		<p>бараа бүтээгдэхүүн худалдаалагдаж 749 мянган төгрөгийн борлуулалт хийгдсэн. Монголын уламжлалт сар шинийн баярыг угтан Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газраас “Нэг Архангай” төрийн бус байгууллагатай хамтран “Цагаан сарын үзэсгэлэн худалдаа 2018” арга хэмжээг Тусгаар тогтнолын талбайд амжилттай зохион байгуулж 12 иргэн 10-15 нэр төрлийн ноос ноолууран эдлэл, монгол дээл, монгол гутал, хүүхдийн буриад гутал, савхин бээлий, ууж хантааз, авдар, тавгийн цар, хэвийн боов, жимс жимсгэнэ зэргээр бүтээгдэхүүнээ төрөлжүүлэн худалдаалж 4,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх, харилцаа, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор төвийн үйл ажиллагаа болон үйлдвэрлэгчдийн бараа бүтээгдэхүүний “ХАМТДАА ХӨГЖЬЕ” катологийн 2018 оны 5 дахь дугаарыг бэлтгэн гаргахаар зураг авалтын ажлыг 2018 оны 03 дугаар сарын 12-аас эхлэн хийж байна. Нийт 167 үйлдвэрлэгч оролцох бүртгэлээ хийлгэн батлагдсан төлөвлөгөө, ажлын хуваарийн дагуу явагдаж байна.</p>				
3	1.2.6 Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг дэмжин, гадаад болон дотоодын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх бараа бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд таниулан сурталчилж хэрэглэгч, захиалагчтай холбоно.	ЖДҮДТ НӨҮГ, Дүүргүүд	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	30	50,0 Нийслэлийн төсөв
		Дүүргийн жижиг дунд өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө засах орны Эрээн хотноо зохион байгуулагдсан “Хятад-Монголын Цагаан сарын үзэсгэлэн”-д жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулах ажлыг зохион байгуулснаар өрхийн				70

		<p>үйлдвэрлэл эрхлэгч 8 иргэнийг 40м2 талбайд түрээсийн үнэ төлбөргүйгээр оролцуулан 9.8 сая төгрөгийн борлуулалт хийсэн байна. Мөн Мишээл экспо худалдааны төвд зохион байгуулагдсан “Монгол-Гоёл 2018” үзэсгэлэн худалдаанд дүүргийн 9 үйлдвэрлэгчийг хамруулж 1.2 сая төгрөгийн борлуулалт хийсэн.</p>				
4		<p>Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зориулан үйлдвэрлэл эрхлэхэд шаардлагатай хууль, эрх зүйн болон төсөл хөтөлбөрт хамруулах чиглэлийн сургалтууд зохион байгуулна.</p>	<p>ЖДҮДТ НӨҮГ, Дүүргүүд</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь</p>	<p>100</p>	<p>70,0 Нийслэлийн төсөв</p>
	<p>1.2.10 Нийслэлийн дүүргүүдэд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон бизнес инкубатор төвийг салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулна.</p>	<p>Дүүргийн бизнес инкубатор төвд 1 дүгээр улирлын байдлаар 2 үйлдвэрлэгчийг шинээр сонгон шалгаруулж, хөнгөлөлттэй нөхцөл бүхий үйлдвэрлэлийн байраар хангаад байна. Улмаар 15 дугаар хороонд байрлах БИТ төв байранд 12 үйлдвэрлэл эрхлэгч, 12 дугаар хорооны БИТ 2 салбар байранд 2, 11 дүгээр хорооны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн БИТ 3 салбар байранд 1 иргэн, 17 дугаар хорооны модон эдлэлийн үйлдвэрлэлийн БИТ 4 салбар байранд 1 үйлдвэрлэгч нийт 16 үйлдвэрлэл эрхлэгч бойжин монгол үндэсний хувцас, сүлжмэл эдлэл, арьсан гутал, зөөлөн оёдол, арьсан эдлэл, электрон хөгжүүлэлт, тавилга угсралтын чиглэлээр нийт 37 ажлын байрыг бий болгон тогтвортой үйл ажиллагааг явуулж байна. 2018 онд 30 зөөврийн ажлын байрыг шинээр хийхээр бэлтгэл ажлыг хангаж, сонгон шалгаруулалтын шатанд явагдаж байна. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 01 дугаар тушаалаар “Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлэх”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг</p>			<p>40</p>	<p>-</p>

		дэмжих”, “Ажлын байрыг дэмжих” хөтөлбөр тус тус батлагдан хэрэгжиж байна. 2018 оны 03 дугаар сарын 12-оос 04 дүгээр сарын 09-ний өдрийг хүртэл аж ахуй болон өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь зориулан эргэн төлөлттэй санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээг зарлаж төсөл хүлээн авч байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан жижиг зээлийн хөтөлбөрт нэгдүгээр улирлын байдлаар 6 ААН, 8 иргэний төсөл дэмжигдэж холбогдох материалыг банканд хүргүүлснээс 2 аж ахуй нэгж байгууллага, 2 иргэний төсөл дэмжигдэж 60 сая төгрөгийн зээлд хамрагдаад байна.					
5		Агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, бүсийн дэглэмийг мөрдүүлнэ.	НМХГ, НАББГ. Дүүргүүд	Хяналт шалгалтад хамрагдах объект, тоо	2000	-	
	3.2.3 Агаарын бохирдол үүсгэгчдийг хүний эрүүл мэндэд хортой байдлаар нь эрэмбэлэн тогтоож, эрүүл мэндэд хамгийн их хор хүргэж буй эх үүсвэрт анхаарал хандуулж ажиллана.	Дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 1592 иргэн, ААНБ-д зурагт хуудас, мэдэгдэх хуудас тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Шалгалтаар 670 иргэн, ААНБ гал түлдэг нь тогтоогдсон. 1-19 хорооны 19 Засаг дарга, 160 хэсгийн ахлагч, 950 иргэн, ААНБ-д /давхардсан тоогоор/ “Агаарын бохирдлыг бууруулахад Таны оролцоо”, түүнд хяналт тавих салбарын сургалтыг тус тус зохион байгуулж, 9 ТВ-д сэрэмжлүүлэг болон хийж байгаа ажлаа сурталчилсан. Мөн 191 иргэн, ААНБ цахилгаанд, хэсгийн халаалтанд 8, төвлөрсөн шугаманд 12 иргэн, ААНБ холбогдсон. 12 иргэн, ААНБ энгийн зуухаа авч сайжруулсан зуухаар сольсон байна. Дүүргийн 9 дүгээр хорооны нэг өрх, айл дулаалгын аяны хүрээнд утаа гаргахгүй яндангүй болж, дулаанаа иж бүрэн цахилгаанаар шийдсэн.				40	-
6	3.2.5 Хөрсний бохирдлыг бууруулах бодлого, эрх	Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний	ЗАА, НБОГ, НМХГ,	Үйл ажиллагааны	100	-	

зүйн орчинг сайжруулна.	хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	НГХДБГ, НАББГ, Дүүргүүд	хэрэгжилт, хувь		
		<p>Дүүргийн Засаг даргын 2017 оны А/764 тоот “Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” захирамжийн хүрээнд дүүргийн гэр хорооллын агаарын бохирдлыг бууруулах, утааг багасгах, хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах баталгааг хангах зорилгоор “ДУЛААЛГЫН АЯН” болзолт уралдааныг 7-19 дүгээр хороодын дунд зохион байгуулсан. Энэхүү болзолт уралдаанд бусдыгаа манлайлагч хороодоор 16 дугаар хороо, 15 дугаар хороо, 11 дүгээр хороо тус тус шалгарч “Өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнагдсан ба 26 хэсгийн ахлагч нар болон иргэний үүргээ биелүүлж, өөрийн санаачлагаар утаагүй орчинд амьдрах нөхцлөө бүрдүүлж, халаалт, дулаанаа цахилгаанаар, шалны халаалтаар, ЭКО тулга болон бусад орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжийг авч хэрэглэж, агаарын бохирдлыг бууруулахад бодитой хувь нэмэр оруулсан нийт 26 иргэнийг "Өргөмжлөл", мөнгөн шагналаар шагналаа. Аяны хүрээнд дүүргийн 7-19 дүгээр хороодод нэг, нэг айл өрхийн амины сууцыг дулаалж, нийт 13 “Загвар өрх”-ийг бий болгосон ба хороодын Ажлын алба нийт 5508 иргэнд “Загвар өрх”-ийн талаар мэдээлэл хүргэн сурталчлан ажиллаж, 184 өрх гэр, амины сууцны халаалтаа цахилгаанаар шийдэж, 155 өрх шинээр шөнийн цахилгааны хөнгөлөлтөд хамрагдсан байна. Мөн 9 дүгээр хорооны нэг өрх аяны хүрээнд утаа гаргахгүй яндангүй болж, дулаанаа иж бүрэн цахилгаанаар шийдсэн. Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан тушаал захирамж А/04-А/19, Нийслэлийн Засаг даргын А/17 тоот захирамж, НМХГ-ын даргын баталсан удирдамжийн хүрээнд дүүргийн 1-18 хороонд 23 улсын /ахлах/ байцаагч нар хяналт тавьж нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа 1592 иргэн, аж ахуйн нэгж,</p>		70	-

		<p>байгууллагад зурагт хуудас, мэдэгдэх хуудас тарааж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Тус ажлын хүрээнд 1-19 дүгээр хорооны 19 Засаг дарга, 160 хэсгийн ахлагч, 950 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад “Агаарын бохирдлыг бууруулахад Таны оролцоо”, түүнд хяналт тавих салбарын сургалтыг тус тус зохион байгуулж, 9 телевизд 3 удаагийн давтамжтай сэрэмжлүүлэг болон хийж байгаа ажлаа сурталчилсан. Зөрчил арилгуулах улсын ахлах байцаагчийн “Агаарын бохирдол, хөрсний бохирдлыг бууруулах, гадна өнгө үзэмжээ сайжруулах” зэрэг 5 заалт бүхий албан шаардлага 220, дүгнэлт 4, акт 7 гаргаж, торгууль 1440,0 ногдуулсан байна. Шалгалтын үр дүнд: 191 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага цахилгаанд, хэсгийн халаалтанд 8, төвлөрсөн шугаманд 12 байгууллагыг холбуулсан. 12 иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энгийн зуухаа авч сайжруулсан зуухаар сольсон байна. Цаашид дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг нүүрс түлэхээс татгалзаж, Янданг 70-80 хувь хүртэл бууруулахаар хяналт тавин ажиллаж байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хорооны хуучин 190 м2 5 өрөө барилгыг “Агаарын бохирдлыг бууруулах мэдээллийн нэгдсэн төв” болгох ажлыг эхлүүлэн гадна болон дээврийн дулаалга, дотор засвар, сантехник, бохир, цэвэр ус, цахилгааны засварын ажлуудыг эхлүүлээд байна. Тус төв ашиглалтанд орсноор дүүргийн иргэд нэг цэгээс мэдээлэл авах, сургалтанд хамрагдах нөхцөл бололцоогоор хангагдана.</p>				
7	4.2.3 Сүрьеэгийн идэвхтэй эрт илрүүлгийг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 10 хувь нэмэгдүүлнэ.	Сүрьеэгүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд сүрьеэгийн өвчлөлийг бууруулах ажлыг дүүргүүдэд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	НЭМГ, ДЭМТ-үүд	Сүрьеэгийн эрт илрүүлэг, эмчилгээний хамралт, хувь	Сүрьеэгийн эрх илрүүлгийг 2016 онтой харьцуулахад 10%-иар, эмчилгээний амжилтийг	-

				5%-иар нэмэгдүүлнэ.		
		Халдварт өвчний эрт илрүүлэгийг эрчимжүүлэх, тархалтыг багасгах зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Илрүүл эмчил сэргийл бид өрх бүрт хүрч ажиллана" эрүүл мэндийн төслийг хэрэгжүүлж байна. 2017 оны хавьтлын судалгааг бүрэн гаргасан ба 1 дүгээр улирлын байдлаар нийт 875 хүн бүртгэгдсэн. Ойрын болон төрлийн хавьтлуудыг нас хүйс, ажил мэргэжил, боловсрол, халдвар авсан болон өвчлөлийн байдлаар гаргаж газарзүйн байршлын хувьд тархалтыг тодорхойлсон. Дүүргийн 1-19-р хорооны ӨЭМТ-н дарга нарт, Цагдаагийн 2 хэлтсийн 73 албан хаагч, СУИС-ын 1,2 курсын 800 оюутанд сүрьеэгийн халдварын талаар эрүүл мэндийн сургалтыг зохион байгуулсан. Цаашид дүүргийн төрийн болон төрийн бус байгууллагууд, нийтийн үйлчилгээний газрууд, сургууль цэцэрлэгүүдэд зохион байгуулахаар төлөвлөж байна.		40	-	
8	4.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	НЭМГ, Дүүргүүд, НБГ, НХГБХГ, НЭМХ, ДЭМТ, Хувийн хэвшлийн эмнэлгүүд	Төрийн өмчит сургууль, цэцэрлэг хамруулах хувь	30	-
	4.2.2 Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.	Хүүхдийн амбулаторийн шүдний эмч нар "Амны хөндийн эрүүл ахуй", "Бага насны хүүхдийн шүд цооролтоос сэргийлэх нь" сургалтуудыг 2018 оны 5 дугаар сард дүүргийн 15, 16-р хорооны сургууль цэцэрлэгүүдэд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Мөн сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийн амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 4-9 сарын хооронд 221, 155, 246, 102-р цэцэрлэгт болон 139-р бага сургууль, 72-р сургуулийн сурагчдад зохион байгуулна. Мөн Сайн хөрш Олон улсын байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд 8 сард урьдчилан сэргийлэх үзлэгийг		40	-	

		дүүргийн 14-19-р хорооны 1500-2000 хүүхдэд зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 6 дугаар сард 221 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүлжүүлэх аян зохион байгуулах, 9-11 дүгээр сард "Сайн хөрш" ОУ-ын байгууллагатай хамтран дүүргийн 13-19 дүгээр хороодын 100-150 хүүхдийн амны хөндийг эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулахаар тус тус бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.				
9	5.4.8 "Худалдаа, үйлчилгээ 2020", "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" нийслэлийн дэд хөтөлбөрүүдийг батлуулж, хэрэгжүүлнэ.	Нийтийн орон сууц, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр байрлаж, иргэдийн ая тух, аюулгүй байдлыг алдагдуулж байгаа ресторан, баар, цэнгээний газруудтай холбоотой асуудлыг шийдвэрлэх чиглэлээр судалгаа хийж, холбогдох журамд нэмэлт, өөрчлөлт оруулан, хэрэгжүүлэх ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	ЗАА, НМХГ, НЦГ, Дүүргүүд	"Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам", "Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх журам"-д нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэрэгжилт, хувь	100	-
		Нийтийн орон сууц, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ойр байрлаж, иргэдийн ая тух, аюулгүй байдлыг алдагдуулж байгаа ресторан, баар, цэнгээний газруудын судалгаа гаргаж ирүүлэх тухай дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2018 оны 01			40	-

	<p>дүгээр 11-ний өдрийн 3/64 дүгээр албан бичгээр дүүргийн 19 хороод руу чиглэл өгч судалгааг авч нэгтгэн нийт 86 байгууллагын /кафе 11, ресторан 53, паб 15, баар 7/ судалгааг УБ хотын ЗАА-ны ХХҮХ-т хүргүүлэв. Эдгээр газруудад мэргэжлийн байгууллагуудтай хамтран үзлэг шалгалтын ажлыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. “Нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг журам”, “Нийслэлийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилгээ эрхлэх журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 29 заалт бүхий саналыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлсэн.</p>		
--	---	--	--

ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

А.ДАМЦАГДОРЖ

ХЯНАСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН
АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА

Б.НАЦАГДОРЖ

БОЛОВСРУУЛСАН:

ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХЭЛТСИЙН
ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР,
НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ХЭРЭГЖИЛТ
ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

М.УРАНЦЭЦЭГ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЦЭЦЭГМАА

